



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 он 11 сар 30 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Дотоод чанарын баталгаажуулалтын журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050”-ын 2 дугаар хавсралт “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.1.7, 2.1.8 дахь заалт, БСШУСайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 тоот тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2.2.2 дахь заалт, БМИҮЗ-ийн “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ын 9.2 дахь хэсэг, ОУУБИС-ийн Захиргааны зөвлөлийн 2022 оны 11 сарын 21-ны өдрийн 7 дэх хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. ОУУБИС-ийн үйл ажиллагаанд мөрдөх “Дотоод чанарын баталгаажуулалтын журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


2. Дотоод чанарын баталгаажуулалтын журмыг 2022 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал (А.Хандмаа)-д хяналт тавихыг үүрэг болгосугай.

3. Дотоод чанарын баталгаажуулалтын ажлыг журмын дагуу төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхийг Дотоод хяналт, Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга (Ц.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



КАН ЮУ ЁЛЬ



Дотоод чанарын баталгаажуулалтын журам

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Өнөөгийн нөхцөлд олон улсын дээд боловсролын салбарт хүчээ авч байгаа интеграцчилалд нэгдэх; Монгол улсын нийгэм, дээд боловсролын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, эрхэм зорилтоо амжилттай хэрэгжүүлэхэд дээд боловсролын сургалтын байгууллагад менежментийн хандлага, арга барилаа бүхэлд нь тэр дундаа сургалтын хөтөлбөрийн менежментийн арга хэлбэрээ тодорхой давтамжтайгаар хянан үзэж шинэчлэх шаардлага тулгарч байна. Ингэж менежментийн хандлага, арга барилыг шинэчилснээр сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөлт, дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо зэрэг менежментийн үндсэн арга хэрэгслүүд бүгд боловсронгуй болгох нөхцөл бүрдэх юм.

1.2. Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо нь сургууль, хөтөлбөрийн тавьсан стратеги зорилтыг бодитой үр өгөөжтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилго бүхий арга хэрэгсэл юм.

1.3. Байгууллагын эрхэм зорилго нь түүний хөгжлийн бүхий л үе шат, үйл ажиллагаанд бодлогыг тодорхойлох менежментийн гол хүчин зүйл юм. Иймд эрхэм зорилгыг хэмжиж болохуйц, бодитой, тодорхой байхуйцаар шинэчилж, сайжруулж байх шаардлагатай.

1.4. Эрхэм зорилгынхоо үзэл баримтлалд нийцүүлэн, стратеги төлөвлөгөө боловсруулах ба түүнд эрхэм зорилгыг хэрэгжүүлэх зорилго, зорилтуудыг хэрхэн хангах арга замыг заах, стратеги төлөвлөгөөг бүрэн жигд, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг хангасан дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

1.5. Стратегийн зорилго, зорилтоо төлөвлөсний дагуу хэрэгжиж буй эсэхийг хянан нягтлах, хэрэгжилтэд зөрүү, дутагдал гарахаас сэргийлэх, зөрүү дутагдал илэрсэн бол засаж сайжруулах, түүнчлэн хэрэгжилт нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйцээр бүхэлд нь хянан сайжруулж байх зорилгоор байгууллагын болон хөтөлбөрийн түвшинд өөрийн үнэлгээ тогтмол хийж тайлагнаж байх шаардлагатай болж байна.

ХОЁР. ДОТООД ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА БАРИЛ

2.1. Сургуулийн үйл ажиллагаанд дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэхдээ эрхэм зорилгыг амжилттай хэрэгжүүлэх; хэрэгжилтийн үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх үүднээс үйл явц үр дүнд суурилсан арга барилд тулгуурлана. Энэхүү арга барил нь ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ, ЧАНАРЫН ХЯНАЛТ гэсэн хоёр хэсэгтэй байна.

2.2. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ нь хэрэгжүүлж буй үйл явцтай холбоотой арга барил бөгөөд сургуулийн үйлчилгээ, бүтээгдэхүүн нь сайн чанартай байхаар үйл явцыг системтэй боловсруулж хэрэгжүүлэх ба түүнд үндэслэн чанарт хяналт-шинжилгээ хийж, чанарыг баталгаажуулна.

2.3. ЧАНАРЫН ХЯНАЛТ нь үйл явцын эцсийн үр дүнд суурилсан арга барил бөгөөд сургуулийн үйлчилгээ, бүтээгдэхүүн нь чанарын шаардлага, хэрэглэгчийн (оюутан, ажил олгогчийн) хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг нягталж тогтооно. Гарсан үр дүнд үндэслэн чанарын алба засах сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

2.4. Сургуулийн үндсэн үйл явц бүрийг, түүний доторх дэд үйл явц бүрийг чанарын менежментийн PDCA арга барилаар удирдвал зохино.

- P (төлөвлөх) - тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, сайжруулахад холбогдох мэдээллийг цуглуулах.
- D (хэрэгжүүлэх) - боловсруулсан төлөвлөгөөний дагуу үйл явцыг туршилт, сорилт гэх мэт тодорхой аргуудаар хэрэгжүүлэх.
- C (хянах) - хүрсэн үр дүн нь төлөвлөсөн зорилтуудтай нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол залруулах зохицуулах.
- A (сайжруулах) - хянах явцад гарсан үр дүнгээс хамаарч төлөвлөгөөг бүрэн сайжруулан үйл явцыг үргэлжлүүлэх, буюу эсвэл төлөвлөх шатнаас (P) дараагийн үйл явцыг эхлүүлнэ.

ГУРАВ. ДОТООД ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

3.1. Сургалтын албаны мэргэжилтнүүд, багш нар, бусад ажилтнуудад дотоод чанарын үнэлгээний чадвар, дадал олоход нь дэмжлэг үзүүлэх.

3.2. Оюутан төвтэй, харилцан идэвхтэй, асууж мэтгэлцэх хандлагыг дэмжих зорилгоор багшлахуйн болон суралцахуйн орчин үеийн арга барилын хэрэглээг үнэлэх; улмаар тасралтгүй хөгжих, байнга сайжруулах соёлыг төлөвшүүлэх.

3.3. “Доороос дээш”, “Дээрээс доош” чиглэсэн үйл явцын эрэлт хэрэгцээ, эрэмбэ дарааллыг харилцан уялдуулах ба оюутны, хөдөлмөрийн зах зээлийн, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүхэлд нь авч үзэн, “ хэрэглэгчид”-д төвлөрөх.

3.4. Чанарын баталгаажуулалтын үйл явцад оролцогч талуудыг татан оролцуулах.

3.5. Ажил олгогчид ба төгсөгчид нь сургуулийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эцсийн хэрэглэгчийнхээ хувьд оролцох.

3.6. Сургалтын албаны мэргэжилтнүүд, бусад ажилтнууд сургуулийн бодлого, үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэгчийн хувьд оролцох.

3.7. Нотолгоонд суурилдаг байх ба шаардлагатай тохиолдолд эрсдлийн тухай ойлголт, менежментийн элементүүдийг аль болох тусгадаг байх.

3.8. Өөрчлөгдөн буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэх хариуцлагаа ухамсарлан тасралтгүй сайжруулдаг байх.

3.9. Чанарын баталгаажуулалтын хүрээ /framework/ нь үечилсэн байдлаар байнга хийгддэг өөрийн үнэлгээ, түүний хариу арга хэмжээнээс бүрдэж байхаар боловсруулах.

ДӨРӨВ. ДОТООД ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБАНЫ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Сургууль нь дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх, чанарын соёлыг төлөвшүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих үүргийг хариуцсан мэргэшсэн ажилтнуудаас бүрдсэн бие даасан бүтцийн нэгж хэлбэрээр ажиллах Дотоод чанарын баталгаажуулалтын алба (ДЧБА)-тай

байна. Энэхүү алба нь бүх салбар, тэнхим нэгжийн хүрээнд чанарын баталгаажуулалтын сүлжээг тогтоож (тэнхимийн эрхлэгч эсвэл багш, ажилтанд ажил үүрэг дээр нь нэмж хариуцуулах журмаар) ажиллана.

4.2. Сургуулийн түвшинд чанарын баталгаажуулалтын шийдвэр гаргах төв хороотой ба салбар нэгжүүдэд хариуцсан дэд хороод буюу ажилтнуудтай байна.

4.3. Сургуулийн бүтцийн бүх нэгжийг хамруулан чанарын баталгаажуулалтын сүлжээг үүсгэн, сургуулийн түвшинд удирдан явуулдаг чанарын менежертэй байна.

4.4. Хөтөлбөрийн түвшинд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг бүхэлд нь хариуцсан орон тооны мэргэжилтэнтэй байна.

4.5. ДЧБ нь хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, сайжруулах зэрэг асуудлуудыг хамаардаг тул дотоод чанарын баталгаажуулалт хариуцсан мэргэжилтнүүд дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- Дүн шинжилгээ хийх болон шийдвэрлэх ур чадвартай байх.
- Судалгааны чадавхитай: Тоон болон чанарын арга, аргачлалуудыг эзэмшсэн байх.
- Манлайлах болон бие даах чадвартай байх.
- Сургууль болон хөтөлбөрийн үйл явцыг гүн гүнзгий мэддэг байх.
- Зохион байгуулах чадвартай байх.
- Боловсролын чанарын баталгаажуулалтын /хөндлөнгийн/ байгууллагаас гаргасан хууль, эрх зүйн орчин, ялангуяа шалгуур үзүүлэлт, журам, зохицуулалтыг сайн мэддэг байх.
- Дээд боловсролын хөгжлийн чиг хандлагыг мэддэг тайлбарладаг байх.

ТАВ. ДОТООД ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБАНЫ ЗОРИЛГО

5.1. Дотоод чанарын баталгаажуулалтын зорилго нь ОУУБИС-ын эрхэм зорилго, стратеги зорилтын хэрэгжилт, хөтөлбөрийн гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх улмаар олон улсын чанарын стандарт, чанарын соёлыг хэвшүүлэх энэ чиглэлээр амжилт гаргаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын сайн туршлагаас суралцан өөрийн сургуулийн чанарыг бэхжүүлэх, дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

5.2. Энэхүү алба нь сургуулийн захиралд шууд (эсвэл дэд захирлаар дамжуулан) тайлагнадаг бие даасан нэгж байх бөгөөд удирдах зөвлөлөөс баталсан дүрэм, стратеги төлөвлөгөө, ДЧБ-ын гарын авлагыг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулна.

5.3. Энэхүү алба нь сургуулийн үйл ажиллагаанд дэмжин туслагч, идэвхитэй оролцогч байж, аливаа алдаа дутагдлыг засч залруулан, чанарт гарсан ахиц дэвшлийг батжуулан бэхжүүлэх замаар чанарыг баталгаажуулдаг гол чиглүүлэгч хүч байна.

ДЧБА-ны үйл ажиллагаа нь сургуулийн стратеги төлөвлөгөөг бүрэн жигд, үр дүнтэй, өгөөжтэй хэрэгжих боломжийг хангахад чиглэх бөгөөд нэн тэргүүнд сургууль, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж байх чиг үүрэгтэй.

ЗУРГАА. ДОТООД ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБАНЫ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

6.1.1. **Сургуулийн (жилийн) өөрийн үнэлгээний тайлан боловсруулах** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь сургуулийн жил бүрийн гаргадаг тайлангийн салшгүй хэсэг болох өөрийн үнэлгээний тайлан боловсруулах ажлыг ерөнхийд нь хариуцах боловч ихэнх хэсэгт нь тэнхим, албад, багш, ажилтнууд ажиллах шаардлагатай)

6.1.2. **Чанарын асуудлаар мэдлэг ойлголтыг дээшлүүлэх** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь тэнхим, салбар, нэгж бүр тавьсан зорилго зорилтондоо хүрэхэд тэмүүлсэн чанарын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг нь ойлгуулж ухамсарлуулахад хүч чармайлт гаргаж ажиллах)

6.1.3. **Тэнхим салбар нэгжүүдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь тэнхим, салбар нэгжүүдэд тогтмол очиж хүрч ажилладаг байх ба тэдэнд дотоод чанарын баталгаажуулалтын үйл явцаа сайжруулахад нь туслах, мэргэжлийн зөвөлгөө өгдөг байхын зэрэгцээгээр сургуулийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо, механизмын дагуу тэнхим, албадын үйл ажиллагаанд аудит хийж үнэлгээ өгөх)

6.1.4. **Тэнхим, салбар, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах** (Тэнхим, бусад салбар нэгж нь чанарын баталгаажуулалтын сүлжээ, холбогдох үйл ажиллагаанд идэвхтэй, нягт хамтран оролцох ба дотоод чанарын баталгаажуулалтын албаны ажилтнууд нь тэдний зохион байгуулж буй үнэлгээний үйл ажиллагааг өөр хооронд нь уялдуулан зохицуулж жигд хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх)

6.1.5. **Үндэсний болон олон улсын чанарын баталгаажуулалтын шалгуур, шаардлагыг таниулах** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь үндэсний болон олон улсын чанарын баталгаажуулалтын шалгуур, шаардлагыг тайлбарлан таниулж, өөрийн сургуулийн онцлог, нөхцөлд тохируулан үйл ажиллагаанд нь тусган хэрэгжилтийг хангаж ажиллах)

6.1.6. **Сургуулийн чанарын баталгаажуулалтын үйл явцад хяналт шинжилгээ хийх** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь заавар, удирдамж өгөх, мэдээлэл цуглуулах, чанарын баталгаажуулалтын үйл явц дахь асуудлуудыг олж тогтоох)

6.1.7. **Хөндлөнгийн үнэлгээний шаардлагыг хангах, үнэлгээнд бэлтгэх** (Чанарын баталгаажуулалтын ажилтнууд өөрийн үнэлгээний үйл явцыг тодорхой давтамжтайгаар тогтмол дотооддоо үйл явцыг сайжруулах зорилгоор жилд нэг удаа, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зорилгоор таван жилд нэг удаа зохион байгуулж, өөрийн үнэлгээний эцсийн тайлан боловсруулах үүрэг хүлээх)

6.1.8. **Хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулах** (Чанарын баталгаажуулалтын ажилтнууд нь аливаа хөндлөнгийн үнэлгээнд бэлтгэж зохион байгуулах ба холбогдох санал асуулгыг авах ажлыг хариуцан гүйцэтгэх)

6.1.9. **Оюутан төвтэй сургалтын аргыг дэмжих** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь оюутан төвтэй сургалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд байнга анхаарч, өөрийн хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаанд оюутны төлөөллийг оролцуулдаг байх)

6.1.10. **Чанарын талаар мэдээллээр хангах** (Сургалтын чанарын үзүүлэлтийн талаар олон талын мэдээллийг дотоодын болон хөндлөнгийн оролцогч талуудад хүргэх, түгээн дэлгэрүүлэх)

6.1.11. **Сургах, хөгжүүлэх** (Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь багш, ажилтан, оюутнуудыг чанарын аливаа асуудлаар сургах, хөгжүүлэх, мэргэшүүлэх нөөцтэй байх)

6.1.12. Сургуулийн өөрийн үнэлгээний дүнг нэгтгэх

6.1.12.1. Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь сургуулийн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгагдсан жил бүр хийгдэх өөрийн үнэлгээний үр дүнг нэгтгэн шинжилж, үйл ажиллагааны чанарыг сайжруулах зөвлөмжийн хамт нийтэд эргэн мэдээлж, санал бодлыг тусгадаг байх.

6.1.12.2. Сургуулийн өөрийн үнэлгээний тайланг үнэлгээний явцад илэрсэн цаашид сайжруулах шаардлагатай арга хэмжээ, хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө, төсвийн саналын хамт удирдах зөвлөлд танилцуулдаг байх.

6.1.12.3. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээг тэнхим, нэгжийн түвшинд хийх бөгөөд жил бүр хяналт шинжилгээ хийж, илүү нарийвчилсан бүрэн хэмжээний үнэлгээг таван жил тутамд хийх.

6.1.13. Оролцогч тал сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах

6.1.13.1. Оролцогч тал, сонирхлын бүлгүүд нь дотоод чанарын баталгаажуулалтанд чухал үүрэгтэй тул тэдний оролцоог хангах, идэвхжүүлэх механизмыг бүрдүүлж, сайжруулж байх. (Сургуулийн доторх оролцогч тал, сонирхлын бүлгүүдэд багш нар, оюутнууд, дээд болон дунд шатны удирдах ажилтнууд мэргэжилтнүүд хамаарна.)

6.1.13.2. Хөндлөнгийн оролцогч тал сонирхлын бүлэгт төгсөгч, ажил олгогчид багтах ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох тухайн хөтөлбөр нь энэхүү хэрэгцээнд нийцэж буй эсэхийг үнэлэхэд тэдгээрийн төлөөллийг оролцуулдаг байх.

6.1.14. Удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх

6.1.14.1. Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх болон бусад үйл ажиллагааг үр дүнтэй удирдан явуулахад шаардагдах мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх ба түүнийг ажиглах боломжоор хангах үүрэгтэй. Иймд сургалтын болон хөтөлбөрийн түвшинд үнэн зөв мэдээ баримт бүрдүүлэх удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлж найдвартай ажиллуулна.

6.1.15. Чанарын баталгаажуулалтын гарын авлагыг мөрдөх

6.1.15.1. Дотоод чанарын баталгаажуулалтын алба нь чанарын баталгаажуулалтын бүхий л бодлого, журам, зохион байгуулалт, арга хэрэгслийг эмх цэгтэй, цогц хэлбэрээр багтаасан үндсэн баримт бичиг болох чанарын баталгаажуулалтын гарын авлагыг боловсруулж батлан дагаж мөрдөх.

6.1.15.2. Чанарын баталгаажуулалтын гарын авлагад боловсролын чанарыг бүхэлд нь хангах бүтэц зохион байгуулалт, бодлого, журам, гүйцэтгэлийн хэмжүүр зэргийг тодорхойлсон байна. Чанарын баталгаажуулалтын гарын авлагад дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн ерөнхий болон чанарын баталгаажуулалтын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлага
- Сургалтын бодлого, журам, тэднийг үнэлэх
- Чанарын баталгаажуулалтын журам, арга хэрэгсэл
- Дараах үйл ажиллагааны нарийвчилсан журам гаргасан байна.
 - Шинэ хөтөлбөр батлах
 - Тодорхой давтамжтайгаар хөтөлбөрийг тогтмол хянаж шинжлэх, үнэлж, дүгнэх
 - Оюутны мэдлэг чадварыг үнэлэх

- Багш, ажилтныг сонгон шалгаруулах, үнэлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх
- Материаллаг нөөц, тоног төхөөрөмж, бусад хэрэгслийн хангамж, нөхцөлийг үнэлэх
- Чанарын баталгаажуулалтын журмын үр нөлөөг үнэлэх гэх мэт
- Бүх оролцогч талууд, сонирхлын бүлгүүд чанарын баталгаажуулалтын гарын авлагыг авч ашиглах боломж нээлттэй байна.